

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-21
1. Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай	9-15
2. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай/	15-21

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар сарын 15-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 33 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Да.Цогтбаатар;
Чөлөөтэй: Х.Баттулга, Э.Батшугар, М.Нарантуяа-Нара, Х.Тэмүүжин, Н.Учрал;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Пүрэвдорж.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Энхбаяр, Г.Уянгахишиг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Г.Уянгахишиг нар хэлэлцэх асуудлын 1 дүгээрт байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах асуудлыг ажлын хэсэг дээр дахин хэлэлцэх шаардлагатай байгаа тул хойшлуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Г.Уянгахишиг нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	3
Бүгд:	15

80.0 хувиар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахыг хойшлуулав./11:47/

Нэг.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай саналыг Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар танилцуулав.

Саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Энхбаяр, Д.Ганбат нар үг хэлэв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар уг асуудлыг дахин нягтлах шаардлагатай тул хойшлуулав./12:13/

Уг асуудлыг 12 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Энхбаяр, Д.Ганбат нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар хариулж, тайлбар хийв.

Д.Цогтбаатар: 1.Монголын Өмгөөлөгчдийн холбооноос санал болгосон Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч Лхагваагийн Данзанноровыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас санал болгосон Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Жаргалсайханы Мөнхболдыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс санал болгосон Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны Хуулийн бодлогын хэлтсийн ахлах зөвлөх Ганбатын Оргилболдыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос санал болгосон Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Сангишаравын Дондовыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс санал болгосон Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Намсрайн Ариунболдыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 12
Бүгд: 16
25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Монголын хуульчдын холбооноос санал болгосон Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн Мөнхдоржийн Мөнхбатыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн санал болгосон Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Баттулгын Дөлгөөнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 4
Бүгд: 16
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Монгол Улсын Засгийн газраас санал болгосон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Чойжилжавын Эрдэнэчимэгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Төрийн бус өмчийн хууль зүйн сургуулиас санал болгосон Шихихутаг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн захирал Бадарчийн Нармандахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 3
Бүгд: 16
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулиас санал болгосон Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Батболдын Амарсанааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 2
Бүгд: 16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи нь ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлсэн нь зохимжгүй учраас Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Баттулгын Дөлгөөнийг дэмжсэн санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 12
Бүгд: 17
29.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Д.Цогтбаатар: “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 20 минут үргэлжилж, 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
11 цаг 33 минут.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирцэд бүртгэгдсэн байгаа гишүүд Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмаагийн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Борхүүгийн Дэлгэрсайхан, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн байгаа юу. Ирээгүй байгаа юу. Учрал гишүүн ирээгүй байна. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн гэсэн ийм ирцтэйгээр, ирц 52 хувьтайгаар бүрдсэн байна. Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Тэгэхээр хэлэлцэх асуудал өнөөдөр 3 асуудал байгаа.

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

2 дугаар асуудал Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай

3 дугаар асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/ ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрээ өгье.

Алтанхуяг гишүүн. Хэлэлцэх асуудлаар би сая асуугаад байгаа юм. Та нэрээ өгчих. Энхбаяр гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүн бас үг хэлэх юм уу. Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Та бүхний өглөөний амгаланг айлтгая. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах энэ асуудал байсан юм. Тэгээд би товчхон хэлчих үү. Тэгэхээр энэ маань ажлын хэсэг байгуулагдаад, би ажлын хэсгийнх нь ахлагчаар, тэгээд гишүүдэд нь Алтангэрэл, Отгонбаяр, Сайнзориг, Тэмүүжин, Уянгахишиг, Энхбаяр нар ажиллаж байгаа. Бид нар бас холбогдох байгууллагуудаас санал авах бичиг явуулаад, саналыг нь авсан. 2 удаа цугласан. Тэгээд өчигдөр бас цуглаж ярилцаад, энэ байгууллагуудаас ирсэн бичиг бас төдийлөн шийдвэр гаргахад, томъёоллоо хийхэд маань бүрэн дүүрэн дэмжлэг болж чадахгүй байна. Тийм учраас дахиж энэ газрууд руугаа бичиг явуулаад, тэд нарын саналыг нарийвчилж авъя.

Дээр нь гишүүд маань бас энэ асуудалтайгаа ажлын хэсгийн гишүүд, дэд ажлын хэсэгтэй бол нэлээн сайн танилцаж, дахиж нухацтай ярья. Хэдийгээр энэ маань хоног хугацаа шахагдсан ийм асуудал байгаа боловч энийг нухацтай ярьж шийдье. Тийм учраас энэ 14 хоногт нь багтахгүй юм байна гээд энэ өнөөдрийн хэлэлцүүлгээс хасаж, ирэх 7 хоног хүртэл хойшлуулж өгөөч ээ гэсэн ийм саналтай байгаа.

Энэ маань нөгөө Үндсэн хуулийн цэцийн шүүгдэгчийг ямар, ямар үндэслэлээр хорих вэ гэдэг асуудлыг л бид нар тодруулах гэж байгаа юм.

Д.Цогтбаатар: Ойлголоо. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатараас Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргая гэсэн ийм хүсэлт тавьж байгаа юм байна. Мэргэжлийн Байнгын хорооны хувьд энэ асуудлыг хэлэлцэхэд Ганбаатар гишүүн асуултад хариулах уу. Энийг бид хэнээс асууж хэлэлцэх вэ гэсэн асуулт байгаа байхгүй юу. Яагаад гэхээр Ганбаатар гишүүн бол бид нар нөгөө хууль зүйн Үндсэн хууль зөрчсөн эсэх хуулийн заалтын асуудал ярих гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр миний ойлгож байгаагаар 2019 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон. Яг энэ заалт дээр шүү. Энэ заалтыг хууль тогтоогч юу гэж ойлгож, бодож оруулсан бэ гэдэг Үндсэн хууль хэлэлцэх үеийн протоколыг гишүүдэд тараамаар байна. Мөн 1992 оны Үндсэн хууль батлах үеийн яг энэ заалтыг хэлэлцсэн Улсын Бага Хурал болон Ардын Их Хурлын хуралдааны протоколыг бас гишүүдэд тараамаар байна. Яагаад гэхээр бид Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудал ярих гэж байгаа учраас.

2 дугаарт Парламентын судалгааны хүрээлэнгээр бусад улс орнуудын Үндсэн хуульд энэ асуудал яаж нутагшсан байдаг вэ, юу гэж ойлгож хэрэглэгддэг вэ гэдэг харьцуулсан судалгаа байдаг бол бас гишүүдэд тараамаар байна. Ойлголт жигдлэх шаардлага байна. Тэгэхгүй бол яг Ганбаатар гишүүний энийг үзэхээр Ганбаатар бол тэгээд байна шүү дээ. Би Их хурлын гишүүн байх хугацаандаа ерөөсөө шалгуулахгүй гэдэг ийм ньюанс яриад байгаа байхгүй юу. Энэ чинь маш том улс төрийн асуудал болно шүү дээ. Хууль шүүхийн өмнө эрх тэгш бүгд. Улсын Их Хурал бол хулгайч нарын орогнодог газар биш. Халдашгүй байдал гэдэг хүрээнд. Тийм учраас энэ цаашдаа Хууль зүйн байнгын хороо энэ асуудал дээр улс төрийн үндэслэл бүхий, хууль зүйн үндэслэл бүхий тайлбарыг Улсын Их Хурлын чуулганд оруулж байж ярихгүй бол энэ их тийм улс төржсөн асуудал болчих вий гэж би санаа зовж байна.

Нэг хулгайч нь Улсын Их Хурлын халдашгүй байдлын ард нуугдах гээд ч байгаа юм шиг. Тийм учраас Үндсэн хуулийн хэлэлцэх үеийн ойлголтын протоколыг гишүүд тараамаар байх юм. Яг юу гэж .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор 2 санал байгаа. Сая ер нь бол Алтанхуяг гишүүн, Энхбаяр гишүүн 2 ерөнхийдөө хэлчихлээ.

1 дүгээрт Үндсэн хуулийн цэцийн 7 дугаар дүгнэлттэй холбоотойгоор ажлын хэсэг байгуулагдаад явж байгаа. Ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байгаа. Энэ асуудал нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тодорхой заалтууд

Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудал байгаа бөгөөд хүлээгээд авсантай холбоотойгоор бид нар тэр заалтыг хэрхэн өөрчлөх ёстой вэ, хэрхэн илүү тодорхой болгох ёстой вэ гэдэг асуудал яригдаж байгаа. Тэгэхээр энэ дээр богино хугацаанд яаран шийдвэрлэхэд бол учир дутагдалтай. Яагаад гэх юм бол тухайн шүүгдэгчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа яг ямар үндэслэл байх юм. Ямар хугацаа тооцох юм гэх мэтчилэн энэ асуудлыг нэн даруй шийдэхэд бол жоохон төвөгтэй байгаа. Энэ утгаараа хуулийн төсөлд оруулах саналуудаа шүүхийн байгууллага, прокурорын байгууллага, Хүний эрхийн Комисс болон холбогдох газруудаас саналыг нь авахаар хүргүүлчихсэн байгаа. Үүний хариугаа хүлээнэ.

Мөн түүнчлэн цэцийн 7 дугаар дүгнэлтэд мөн тусгасан байгаа. Энэ хуулийн хэрэгжилтийг түдгэлзүүлэх хугацааг нь 2026 оны 1 сарын 1-ээс гэсэн байгаа. Тийм учраас ажлын хэсгийн болон чуулганаар хэлэлцэхийн хувьд тодорхой хэмжээнд хугацаа байгаа гэж үзэж байгаа учраас энийг хойшлуулж өгөөч ээ гэдэг хүсэлт байгаа юм.

2 дугаар хүсэлт бол Ганбаатар гишүүний гаргасан хүсэлттэй холбоотойгоор сая Энхбаяр гишүүн ч гэсэн хэллээ. Энэ асуудал өөрөө нэлээн ньюанстай асуудал байгаад байгаа. Тийм учраас яг энэ гаргасан хүсэлтийн хүрээнд бид нар одоо хэлэлцээд явах өөрөө төвөгтэй байгаа учраас ажлын хэсэг байгуулах, улмаар ажлын хэсэг өөрөө тодорхой судалгааны байгууллагаа ажиллуулаад, тэр харьцуулсан судалгаа болон яг 2019 онд Үндсэн хуульд өөрчлөлт оруулахдаа яг ямар үндэс агуулгаар оруулсан юм. Их Хурлын тухай хууль дээр энэ Үндсэн хууль зөрчсөн, нөгөө талдаа гэмт хэрэгт холбогдсон гэдэг энэ 2 асуудлыг яаж ялгаж зохицуулсан юм гэдэг дээр ажлын хэсэг гаргаад, судалгаагаа ярилцаад тодорхой үндэслэлтэй тайлбартайгаар хэдүүлээ Байнгын хорооныхоо хэлэлцүүлгийг хийхгүй өнөөдрийн хэлэлцүүлэг учир дутагдалтай болохоор байгаа учраас тэр 2 дахь асуудлын хүрээнд ажлын хэсэг байгуулаад явах саналтай байгаа.

Д.Цогтбаатар: Одоо Уянгахишиг гишүүн, Алтанхуяг гишүүн 2-ын эхний тэр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн асуудлаарх саналыг хойшлуулъя. Яагаад гэвэл угаасаа өөрсдөө энэ дээрээ ажилласан. Уг нь цаг хугацааны нээрээ хязгаартай байгаа шүү. Тэгээд яах аргагүй би бас хууль харсан. 14 хоногт батална гээд гарчихсан байгаа нь Их Хурлын гишүүд ингэхийг хэн ч тооцоогүй байхад тэр дээр тийм аферматив норм заалттай юм байна лээ. Өнөөдөр тэгэхээр энийгээ хойшлуулъя гээд энийг дэмжье гэсэн томьёоллоор санал хурааа. Тэгээд гишүүд өөрсдөө дэмжиж байгаа бол энэ гишүүдийн л бүрэн эрхийн асуудал. Энэ рүү би ч халдах хэрэггүй. Тэгэхээр энийг хойшлуулъя гээд санал хураагаад, та нар өөрсдийнхөө л саналыг хийгээд явчих. Эхний асуудал.

2 дахь асуудлыг би Ганбаатар гишүүн ээ, би бас өөрийнхөө байр суурийг хэлээд, хэдүүлээ санал хураагаад явчихъя. Тэгэхээр ер нь янзалъя гэж байгаа шүү дээ. Харин тэгэхээр бид нар энэ дээрээ сайн үндэслэлтэй л ажиллах шаардлагатай байгаа учраас тэгээд үнэхээр ажлын хэсэг нь өөрөө бид нарын ажил бэлэн биш байна гэхэд ийм нарийн хуулийг бид нар хэлэлцээд явна гэдэг ойлголт угаасаа байхгүй. Тэгэхээр саяын томьёоллоор Алтанхуяг гишүүний саналыг ямар хугацаагаар хойшлуулъя гэх вэ. Тэгэхээр ингээд Алтанхуяг гишүүн, Уянгахишиг гишүүний гаргасан саналын дагуу энэ асуудлыг хоёр 7 хоногоор хойшлуулъя гээд энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Байж байгаарай. Санал хураалтдаа бэлдээрэй. Уучлаарай. Санал хураалтыг түр зогсооё. Санал хураалтдаа бэлдье. Санал хураалт. 80 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь асуудал Ганбаатар гишүүний саналтай холбогдуулаад сая Уянгахишиг гишүүн, Энхбаяр гишүүн бас саналууд хэлж байна. Энэ Ганбаатар гишүүн энэ саналыг гаргаж тавьж байгаа нь бол зүй ёсны асуудал. Яагаад гэвэл хууль өөрөө ойлгомжгүй байгаа учраас энийг ойлгомжтой болгох, нэг талдаа гаргаж мухарлах бол шаардлага байгаа. Өнөөдөр хэлэлцэхэд үнэхээр энэ дээр бол материал юмнууд бол дутаж байна. Их Хурал дээр одоо жишээлбэл яг өнөөдөр хэлэлцээд явъя гэхэд би өөртөө хүртэл материал бэлдүүлэх гээд надад гүйцэд орж ирээгүй байж байгаа. Сая Энхбаяр даргын хэлээд байгаа наадах чинь гээд хэлэлцүүлгийн явцад яг тухайн заалтаар ямар санаатай гишүүд юу ярьж байсан юм бэ гэдэг энэ бүх юмнуудаа бид нар авч үзэх хэрэгтэй. Сабскунт практик буюу яг энэ зүйлийн дагуу хэрэгжиж, практик хэрэглээ ямар байсан юм бэ гэдэг чинь энэ чинь яг хууль тогтоогчдын өөрийнх нь практик учраас хууль тогтоогчид юу бодож байсан юм бэ гэдгээ яг үйлдлээрээ харин харуулдаг байхгүй юу. Тэрийгээ хууль дээрээ тодорхой илэрхийлээгүй байсан ч хийгээд байгаа үйлдлүүд нь бол ийм юм санаж хийсэн юм байна гэдгээ харуулдаг. Тэгэхээр энэ бүх юмнуудаа бид нар маш нарийн сайн харж байж энэ хуулийн цаад санаа чинь юу байсан юм бэ гэдгийг хэдүүлээ ярихгүй бол жишээлбэл Энхбаяр гишүүний бас тэр гаргаж хэлж байгаа наадах чинь ийм байдлаар сүүлдээ уншигдаад явчих эрсдэл байгаад байна шүү гээд. Тэгэхээр энэ дээр миний бол санал. Энийг 7 хоногоор, ажлын хэсэг байгуулж болно. Ингэе. Тэгвэл энэ асуудлаа хэлэлцэж эхлээд тэгээд энэ дээр яг ийм бид нарт асуудал байгаа болохлоор хойшлуулаад явъя гэж бодож байна. Тэгвэл ингээд өөр хэлэлцэх асуудлаар санал байхгүй байгаа учраас хэлэлцэх асуудлыг баталлаа.

Ингээд асуудлуудаа хэлэлцээд явъя.

Тэгэхээр эхний хэлэлцэх асуудал.

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатараас 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын даргад Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай асуудлыг өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай танилцуулна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

С.Ганбаатар: Эрхэм гишүүдийн амар амгаланг айлтгая. Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлийг үндэслэн энэхүү хүсэлтийг гаргасан юм.

Улсын Их Хурлын гишүүн нь гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх, энэ асуудлаар эргүүлэн татах асуудлаар би санал та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүний ард түмний төлөөлөх бүрэн эрхээ саадгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Улсын Их Хурлын гишүүнийг эргүүлэн татах үндэслэлийг зохицуулсан зохицуулалт юм. Үндсэн хуулийн энэ зохицуулалт нь Улсын Их Хурлын гишүүн өргөсөн тангаргаасаа няцсан бол эсхүл Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэхээр хуульчилсан байгаа. Холбогдсон тухай асуудлыг биш одоо чинь бид бүр холбогдоод, хулгайч болоод, баахан балбаж байгаа шүү дээ. Үүнийг үндсэн хуулийн онол зорилгын хүрээнд авч үзэхэд, нэгд, гишүүн өргөсөн тангаргаасаа няцсан

үйлдэл, эс үйлдэхүй гаргасан эсхүл 2-т Улсын Их Хурлын гишүүн болсноос хойш /болсноос хойш/ гэж байгаа шүү. Гэмт хэрэгт холбогдохтой холбоотой асуудлыг Үндсэн хуульд заасан. Өөрөөр хэлбэл парламентын гишүүн өөрийн хийсэн үйлдлийн төлөө бусдын адил шууд халдлагад өртөхгүй буюу хариуцлага хүлээхгүй гэсэн энэхүү хамгаалалтыг хуульчилж, гэмт хэрэгт холбогдох асуудлыг өргөсөн тангарагтай холбон хуульчилсан байтал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46.2.3 дахь заалтууд нь Үндсэн хуулиар олгосон Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх халдашгүй байдлыг илтэд дордуулж зөрчсөн байна гэж байгаа юм.

Миний хэлэх гээд байгаа санаа бол Их Хурлын тэр хамгаалалтын ард нуугдаад байх биш, гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг ярилаа л бол бүрэн эрхийн тухай ярьж л гэж энэ Үндсэн хуулийн заалтыг эш татаж ярьж байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2-т гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд түүнийг албадан саатуулах, баривчлах, цагдан хорих зайлшгүй шаардлагатай гэж үзсэн Улсын ерөнхий прокурорт бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан гэсэн заалтад дүн шинжилгээ хийж үзэхэд гишүүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэсэн гэсэн нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3-ын өргөсөн тангаргаа зөрчсөн эсхүл Улсын Их Хурлын гишүүн болсноос хойших цаг хугацаатай холбоотой эрүүгийн хэрэг үүсгэсэн асуудал бус тухайн гишүүнд холбогдуулан амьдралын цаг хугацаанд нь аль ч үед хийсэн үйлдэл, эс үйлдэхүйтэй нь холбогдуулан хэрэг үүсгэж болохоор үүнээс улбаалан түүнийг албадан саатуулах, цагдан хорих, баривчлах асуудлыг шууд Улсын Их Хуралд Ерөнхий прокурор оруулахаар хуульчилсан байгаа нь Үндсэн хуулийн 29.3-ыг зөрчиж, Улсын Их Хурлын гишүүний ард түмнийг төлөөлөх үндсэн үүрэгт саад болсон зохицуулалт байна гэж үзэж байна.

Ийнхүү Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 45.2.3 дахь заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 2.3 дахь заалтууд зөрчиж буй асуудлаар Үндсэн хуулийн цэцээр шийдвэрлүүлэх хүсэлтийг гаргаж байгаа тул холбогдох хуулийн дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлж шийдэж өгөхийг хүсэж байна.

Д.Цогтбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье. Ер нь үг, асуултаа хамт явчихъя. Ингээд асуулт асуух гишүүн Алтанхуяг гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн ороод ирсэн байна. Ганбат гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Ганбаа гишүүний гаргасан саналыг харлаа. Урьд өмнө нь түрүүн Энхбаяр гишүүн бас ярьсан даа. Хэнээс асуух юм бэ гэж. Тэгээд Ганбаатар гишүүн хариулах юм уу, Байнгын хорооны дарга хариулах юм уу. Дэгээрээ энэ чинь хэн юм. Тэгээд Ганбаатар гишүүнээс л асууя даа. Санал гаргаснаар нь. Урьд өмнө нь яг ийм асуудлаар Цэцэд асуудал үүсгэж байсан тохиолдол, кэйс байна уу. Хэрвээ байсан бол цэц юу гэж шийдэж байсан байна. Таны гаргаж байгаа асуудлын бас нэг үндэслэл бол яг энэ Улсын Их Хурлын гишүүний тангараг өргөж, тангаргаасаа няцуул гээд байгаа юм гэж үзэхээр асуудлыг яг гишүүний бүрэн эрхийн хугацаанд нь асуудлыг ярих ёстой юм уу. Эсвэл урьд өмнө нь хожид хэд 10 жилийн өмнө үүссэн хэрэгтэй хүн байвал энэ асуудлыг яг юу гэж бодож байгаа юм та. Энэ асуудлыг гишүүний бүрэн эрхийн хугацаанд нь 10 жилийн дараа үүсгэж оруулж ирээд, бүрэн эрхийг нь түдгэлзүүлнэ гээд асуудал ярьж байх шиг байна. Тан дээр бол. Бид бүхэн ойлгохдоо бол яг энэ тангараг өргөнө гэдэг бол гишүүний бүрэн эрхийн хугацаанд

хуулийг дээдэлж шударгаар ажиллана гэж төр нийтийн өмнө тангараг өргөж байгаа юм. Энэ хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийн асуудал яригдах юм уу. Эсвэл урд хожид үйлдсэн хэргийн асуудлыг оруулж ирээд одоо бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх асуудлыг яриад байгаа нь та юу гэж бодож байгаа юм. Ямар байр суурьтай байгаа юм. Энэ дээр хариулт өгөөдхөөч.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

С.Ганбаатар: Энэ асуудлыг өнөөдөр хувь хүний хувьд надтай холбож та нар маань бодохгүй байх. Тэгэхдээ Монгол Улсын парламентын гишүүн хүн ард түмнээс төрийн дээд эрх мэдлийг шилжүүлэн авч, сонгуулиар авсны хувьд хэнээс ч айхгүйгээр хараат бус байдлаар уг үзэл бодлоо илэрхийлэх тэр эрхийн төлөө өнөөдөр энэ асуудлыг би оруулж байгаа юм шүү. Тэрнээс биш миний хувьд бол холбож битгий бодоосой, яриасай. Хойш хойшдын парламентад залуу парламентын гишүүн, залуу хойч үеийн дараагийн үе мөрдөж, шалгуулж, зовж зүдэрч, хулгайч гэж гүтгүүлж, доромжлуулж баахан юм болохын оронд үндсэн хуулийн заалт дээр Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эргүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудал гарлаа л бол тэгж нийгмээр бүр ингэж бие биеийгээ хулгайч, хэн нэгнийгээ буруутан зөрөөтэй гэхгүйгээр шууд Их Хурал дотроо орж ирээд, бүрэн эрхийг нь түдгэлзүүлдэг байгаач. Энэ Үндсэн хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхэд гажуудал үүсээд байна гэдэг асуудлыг би ярьж байна. Тэгээд дээр нь нэмээд үгүй ээ, энэ чинь Улсын Их Хурлын сонгуульд орох гэж бид чинь махаа зулгаадаг биз дээ. Тэгээд яг орохоос өмнө бол Авлигатай тэмцэх газраас, шүүхээс, прокуророос, цагдаагаас санагдаж байна. Маш олон бичгүүдийг гэмт хэрэггүй гээд. Иргэн байхдаа огт гэмт хэрэггүй байсан мөртөө л гишүүн болонгуут л тэгээд л баахан юмыг нь сөхнө гэдэг бол энэ гишүүний хараат бус байдлыг нөлөөлж байна гэж би ойлгож байгаа. Энэ асуудлыг цэгцэлж, Их Хурлын гишүүд бид ярьж, Цэцээр энэ асуудлыг бас цэгцлэх цаг болсон. Дээр нь нэмээд хэлэхэд түрүүн маш чухал юм асууж байна. Өмнө нь байсан хэргүүдийг ингээд сөхөх үнэн. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс хойш бол энэ асуудлыг би Их Хурал дээр тавигдаагүй гэж үзэж байна. Энэ өмнө нь бол байсан иргэнээс тавигдаж байсан.

Тэгэхээр энэ асуудлыг Улсын Их Хурал дээр Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэх ёстой гэдэг саналтай байна.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Энэ Ганбаатар гишүүний хэлж байгаа зөв л даа. Энэ Ганбаатар гишүүний асуудал биш юм. Би иймэрхүү байдалтай гишүүдийн нэрийг хэл гэвэл их олон гишүүдийн нэр хэлнэ. Энэ парламент, өмнөх парламент, тэрний өмнөх парламент. Ер нь товчхондоо бол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй дархан байдал гэж юу юм бэ гэж. Энийг манайхан сонин хэвлэлээр пи ар хийсээр байгаад хэдэн хулгайч нар энэ халдашгүй дархан байдал гэдгийн цаана нуугдаж байна гэж байгаа юм. Би тэр хонгилоор нь яваад, дахиад ингээд Их Хурлын гишүүн байхдаа баахан шүүх хүртэл явсан хүний хувьд хэлэхэд би өөрөө туршилтын туулай болсон л доо. Би юм хэлэхгүй л явсан. Энэ бол маш буруу жишиг. Яагаад буруу жишиг вэ гэхээр хүн гэмт хэрэг үйлдсэн эсэх нь тэр дотроо Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн эсэх нь тодорхойгүй байхад одоо манай хууль дээр биччихээд байгаагаар гэмт хэрэгт холбогдуулан шалгана гэж хэлээд л бүрэн эрх түдгэлзүүлнэ,

янз бүрийн юм ярьдаг. Бүрэн эрх тэгээд түдгэлзүүлчихлээ гэж бодъё. Тэгээд тэр гишүүн ч явсаар байгаад гэмт хэрэг үйлдээгүй гээд гараад ирвэл тэгээд хэн хариуцлага хүлээх юм. Тэр хооронд нь саяын Ганбаатар гишүүний хэлж байгаа шиг хэвлэл мэдээлэлд ам руу нь мөнгө өгөөд, бөгсөөр нь чихээд гартал нь ийм мөнгө өгч байгаад хүнийг бол зүгээр л гэмт хэрэгтэн болгочхож байна шүү дээ. Үгүй ээ, би энийг чинь 10 жил хараад явж байна. Өөрөө үүний 1 объект болоод явж байна шүү дээ. Тийм учраас бид нар энийг бол ярих ёстой. Би энийг гишүүний асуудал гэж үзэхгүй байгаа шүү. Энэ бол манай институтийн тухай асуудал. Яагаад тэгж байгаа вэ гэхээр бид нарын үед ч байсан, одоо ч байж байна. Улсын Их Хурлын гишүүний кнопыг барьцаалдаг. Энэ хууль хяналтын байгууллага дээр хэрэг үүсгэсэн гэдгээр нь кнопод нь халдаж байгаа байхгүй юу. Бид нар чинь Их Хурлын гишүүд гэдэг чинь ард түмний мандат авсан хүмүүс шүү дээ. Бид нар чинь хууль батлах ёстой шүү дээ. Улс орны бодлогын асуудлыг гаргахад кнопоороо 1 санал ч гэсэн хэрэгтэй шүү дээ. Гэтэл одоо та нарт тулгарчихсан асуудал байна шүү дээ. Засгийн газрыг огцруулна. Их Хурлын даргыг огцруулна. Үгүй ээ, ямар нэгэн шийдэл гаргах хэрэгтэй биз дээ. Энэ дээр та нарын кнопыг барьцаалаад байвал яах юм. Ардын намынхан жишээ нь. Би энийг чинь бол 10 хэдэн жил ярьж байна. Хонгилыг чинь яриад, дахиж өөрөө хонгилдуулаад, дахиж өөрөө мөрдүүлээд, эхнэрээ хүртэл тагнуулаад, дараагаар нь Их Хурлын гишүүн байж байж шүү. Дараагаар нь би прокурорын байгууллага 1 тогтолцоотой, 1 дарангуйлагчийн доор байдгийг ойлгоод шүүх бол наанатай, цаанатай юм ярьдгийг ойлгоод, шүүхдүүлээд ингээд явж байгаа шүү дээ.

Тийм учраас би Ганбаатар гишүүний энэ хөндөж байгаа асуудал нь зөв зүйтэй юм. Хэдүүлээ ерөөсөө энэ Их Хурлын ажлын хэсэг, манай Байнгын хороо бүр ноцтой судалгаа шинжилгээ гаргаад нэг мөр болгох ёстой. Их Хурлын гишүүнийг 10 жилийн өмнөх дур нь хүрэхээрээ 10 жилийн өмнө, 15 жилийн өмнөх асуудлыг сөхөөд гэмт хэрэг үүсгэсэн гээд яриад байгаа юм. Ганбаа гишүүн тийм л юм ярьсан шүү дээ. Үгүй ээ миний.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 минут нэмээд өгье Алтанхуяг гишүүнд.

Н.Алтанхуяг: Энэ одоо ерөөсөө би тэгээд сүүлийн үед харж байгаа юм. Энэ хулгайч дарга нар толгой дээр нь гарахаар хууль хяналтын байгууллага ингэж давардаг юм уу, яадаг юм. Тэгээд нөгөөдүүлдээ үг хэлж чаддаггүй. Одоо Их Хурлын гишүүд та нар амиа бодож болохгүй. Би бол хэн нэгэн гишүүнийг хамгаалах тухай яриагүй байна, өөрийгөө ч хамгаалахгүй тухай биш. Институтээ хамгаалмаар байна. Яах гэж тэгвэл бид Их Хурлын гишүүн гэж ард түмнээс сонгогдож гарч ирдэг юм. Кнопоо дарж чаддаггүй юм бол үхсэнээ хийж энд сууж байдаг юм. Хүний кнопыг яахаараа тэгдэг юм.

Би ганцхан кэйс хэлэхэд манай Засгийн газрын гишүүнийг намайг огцрох үед урьд орой нь уулзаад, тэгээд маргааш нь тэр гишүүнийг кнопыг нь даруулахгүйгээр явуулчхаж байгаа юм. Засгийн газрынхаа огцрох асуудалд Засгийн газрын гишүүн орж кнопоо дарж чаддаггүй тийм л байдалтай байсан. Тэр үргэлжлээд байгаа байхгүй юу. Тийм учраас хэдүүлээ энийг янзалж зөв болгох хэрэгтэй. Ажлын хэсгээ байгуулна уу, яана уу мэдэхгүй. Серьёзны ажиллая. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Би Алтанхуяг гишүүнтэй санал нэг байгаа юм. Энэ Ганбаатар гишүүнээс салгаж ярихгүй бол улс төржөөд үндсэн асуудал нь бүдгэрэх гээд байгаа юм. Би бол ХҮН намын төлөөлөл Уянгахишиг гишүүнээр ахлуулаад, одоо Алтанхуяг

гишүүн их туршлагатай хүн шүү дээ. Монгол Улсын түүхэнд хамгийн удаан хонгилоор чирэгдсэн Ерөнхий сайд байгаа шүү дээ. Тэгэхээр Алтанхуяг гишүүнийг оруулаад, өөр хэн байдаг юм тийм ээ, бас хүмүүс оруулаад ажлын хэсэг гаргаж яримаар байгаа юм. Энэ их олон кэйсүүд болж байсан байхгүй юу. Одоо жишээлбэл Ж.Эрдэнэбат гэж Ерөнхий сайд бол Их Хурлын гишүүний бүрэн эрхтэйгээ байгаа мөртөө цагдан хоригдчихсон юм. Би шүүхийн шийдвэрийг нь үзэж байсан байхгүй юу. Тэгсэн чинь тэр Идэр гэж хонгилын мастер чинь бол ингэж шүүхийн шийдвэрээ гаргасан байгаа байхгүй юу. Улсын Их Хурлын гишүүнд халдашгүй байдал гэж байхгүй. Улсын Их Хуралд л байгаа. Энэ кэйсийг жишээлбэл үзэх хэрэгтэй байна. 2019 онд Үндсэн хуулийн өөрчлөлтийг оруулж байх үед юу гэж хууль тогтоогч ярьж, сонгогчтой ярьж, мөн судалгааны дүгнэлт юу гэж гарч байсан бэ гэхээр энэ Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын ард хулгай хийчхээд ерөөсөө нуугдаад шалгуулахгүй байна. Эгүүлэн татдаг больё гэж ард түмэн ярьж байсан. Яг энэ үндэслэлийг ярьж байгаад 2019 оны өөрчлөлт хийсэн байхгүй юу. Тэгээд одоо та бүхэн санаж байгаа бол хууль тогтоогч нар юу гэж ярьж байсан гэхээр одоо бол хулгай хийсэн хүн бол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын ард нуугдах аргагүй болсон гэж ярьж байсан шүү. Тэр үед яг тэгж ярьж байсан. Гишүүд бүгд тэгж ярьж байсан. Ийм өөрчлөлт хийлээ Үндсэн хуульдаа гэж ярьж байсан шүү. Тэгээд одоо яг Байнгын хорооноос ямар томъёоллоор жишээлбэл санал хураах юм. Тогтоолын төсөл байх юм уу, танилцуулга юм байна уу. Би энийг яриад байгаа байхгүй юу. Нэг юм бэлдэх хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхийн тулд судалгаа хийх хэрэгтэй байгаад байна шүү дээ наадах чинь. 2019 оны өөрчлөлтийг яг ямар байдлаар ойлгож, бүр ингэж хууль тогтоогчид баталсан юм бэ. Хэлэлцүүлгүүдийн шатад яаж энийг ойлгож явж байсан юм бэ гэдгийг ярихгүй бол болохгүй байгаад байгаа юм.

Алтанхуяг гишүүний яриад байгаа аягүй чухал ньюанс хэлээд байгаа юм. Улсын Их Хурлын гишүүн хүнийг гишүүний бүрэн эрх нь дуусаагүй байхад шүүх хурал болж болох уу гэдэг ньюанс байгаа шүү. Алтанхуяг гишүүн бол шүүх хурлаар орчихсон байхгүй юу. Гишүүнийхээ бүрэн эрхтэйгээр шүүхийн шийдвэр гарчихсан. Одоо дахиад урвугаар нь харсан нэг томъёолол манай Да.Цогтбаатар дээр яваад байгаа шүү дээ. Би гишүүн болохоос өмнө үйлдсэн миний гэмт хэрэг дээр би одоо татагдахгүй гэж яриад яваад байгаа байхгүй юу. Би гишүүн болчихоод хэрэг хийгээгүй. Би гишүүн болохоосоо өмнө гэмт хэрэг хийсэн юм гэж яриад байгаа байхгүй юу. Энэ чинь ийм зөрчилтэй юм яриад байгаа шүү дээ. Энэ бүх ньюансуудыг Хууль зүйн байнгын хороо мэргэжлийн маш үндэслэлтэй чуулган руу авч орохгүй бол энэ маш том улс төрийн асуудал..../минут дуусав/

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Энэ чинь иймэрхүү нэг л сонин сонсогдоод байна л даа. Бид нарыг чинь яриад байгаа шүү дээ. Энэ Улсын Их Хурал бол ил тод, шилэн тунгалаг байхын тийм нэвтэрхий илэрхийлэл байх ёстой шүү дээ. Хамгийн л гайгүй хүмүүс нь энд ирж ажиллаж байх ёстой. Ард түмний сонголтоор. 10 жил, 20 жилийн өмнө юу болсон, ямар юманд холбогдсон, хэн мэдэх вэ дээ. Шинээр үүссэн нөхцөл байдлаас болоод ямар нэгэн байдлаар гарч ирж болно. Тэгээд гадуур бид нарыг яриад байна шүү дээ. Энэ Улсын Их Хурал 1 хулгайчдын үүр боллоо гэж. Одоо ч гэсэн тэгээд л нүүрсний хулгайч биш, бишгүйгээрээ ялгарах гээд л үзээд л байна. Хэн нь бага хулгайлсан, хэн нь их хулгайлсан гээд. Тэгэхээр чинь бид нар шүүх засаглал, энэ бүх хууль юмыг тогтоодог. Тэгээд тэр даргалж байгаа дарга нарыг Улсын Их Хурлаас томилдог. Цагдааг ч бид нар томилдоггүй л дээ. Засгийн газрыг мөн Авлигатай тэмцэх газрыг. Тэгээд хуулийг нь хийж байгаа. Тэр дарга нарыг нь

томилж байгаа. Тэр лүү болохоор иргэд маань очоод шалгуулж болоод байдаг. Монгол Улсын иргэд бүгдээрээ. Бид нар болохоор тэд нараасаа болгоомжлоод байдаг юм уу, яадаг юм, итгэдэггүй юм уу. Тийм байж болохгүй л дээ. Тэгээд ёс суртахуун гэдэг юм хаа сайгүй байхгүй болчихоод байна. Энэ Их Хурлаасаа л эхэлмээр байгаа байхгүй юу. Жишээлбэл надтай холбоотой янз бүрийн асуудал гарлаа, энэ тэр гээд яриад, хууль хяналтын байгууллага шалгая, барья гэх юм бол би өөрөө сайн дураараа татгалзаад, шалгуулна. Тийм жишиг бий болох гээд л явж л байна л даа. Төлөвших гээд.

Манай Ганбаатар гишүүн бол мэдээж хэрэг өөр талаас нь хандаж байгаа байх. Шударга ёсны эталон болсон хүн л дээ. Улсын Их Хуралд нэлээн хэд сонгогдчихсон. Тэгээд тэр халдашгүй байдал гэдгийг бол бас зөв ойлгомоор байна. Бид нар тэр ард түмнийхээ төлөө ямар нэгэн хууль, тогтоол санаачлаад, тэрний төлөө явж байгаа хүнд л халдашгүй байдал нь Улсын Их Хуралд байна уу гэхээс биш, ямар нэгэн гэмт хэргээ далдлах эсвэл тэрнээс айж болгоомжилсон хүмүүс энэ Улсын Их Хурал дээр цугладаг байж болохгүй л дээ. Ямар ч үнээр хамаагүй. Тийм ойлголтыг бид нар ард түмэндээ хэрхэвч өгч болохгүй. Иргэдээ болохоор очиж шалгуул гээд байдаг, шалгаад байдаг. Өөрсдөө болохоор шалгуулдаггүй. Тэр хуулийг нь гаргачхаад, тэр дарга нарыг нь томилчихоод. Ингэж болохгүй. Энэ чинь нөгөө дабл стандарт гэдэг юм уу, тийм юмыг чинь бий болгочих гээд байна. Тэгж иргэд хараад байна. Тэгээд Улсын Их Хурлын нэр хүнд улам ч унана. Иргэд ч бүр үзэн ядаж эхэлнэ. Ийм байж болохгүй л гэдгийг би бас сануулаад хэлчихье гэсэн ийм ойлголттой байна.

Ер нь тэр жагсаалт энэ тэртээ бол өмнө нь сонгогдож байсан гишүүдээ оруулмаар юм билээ. Тэгэхгүй бол намын дарга нарын баахан хамаатан садныг дүүргэдгийг нь болимоор юм билээ. Тэрийг ч Хууль зүйн байнгын хороо харж үзээд .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт авч, хариулт авч дууслаа. Асуулт асууж, хариулт авч дууслаа. Би энэ дээр ийм саналтай байна. Ер нь бэлдэх явцдаа би ч нэлээн юмнууд сөхөж харлаа. Тэгээд хэдүүлээ ул суурьтай харахгүй бол энэ дээр тодорхойгүй асуудлууд байна. Үнэхээр тодорхойгүй. 2012 онд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт байж байна. Тогтоол байж байна. Тэгээд энэ дээр болохоор яг иймэрхүү асуудал дээр Үндсэн хууль зөрчжээ гээд юу гарчихсан байж байгаа. Эргээд тэгээд Үндсэн хуульд энэ асуудал маань яг энэ томьёололтойгоо ороод ирчихсэн байж байгаа юм. Тэгэхээр Их Хурлын тухай хууль дээр ороод ирчихсэн байж байгаа юм. Тэгэхээр үүнээс авхуулаад бүр ингээд цаанаас сууриараа зөрчилтэй юмнууд яваад байна шүү дээ. Практик авч үзлээ. 19 кэйс байх шиг байна. 16 кэйс байна. Яг үүнтэй холбогдсон. Тэгэхээр энэ бүгдийг хэдүүлээ авч үзэхгүй бол нээрээ болохгүй. Гэхдээ энийг бол манай Хууль зүйн байнгын хороо дээр бид нар энийг ярьж, тэгээд тэр Үндсэн хуулийн цэц дээрээ очих уу. Энийг нэг талдаа гарч мухарлахгүй бол гэхдээ энийгээ шийдэхээсээ өмнө бид ядаад хууль тогтоогчид өөрсдөө энд ойлголттой бүрэн нэгдсэн ойлголттой болж авах хэрэгтэй байна.

Нэг зүйл байгаа. Энэ дээр тэр Энхбаяр гишүүний асуугаад байгаа ч гэсэн Ганбаатар гишүүн бол яах аргагүй өнөөдөр тулгамдчихаад байгаа асуудлыг ний нуугүй зоригтой гаргаад тавьчихаж байгаа байхгүй юу. Энийг бид нар буруу хэлэлцээд явах юм бол одоо яг Энхбаяр гишүүний ярьж байгаа асуудал шууд гарч ирнэ. Энэ ордон дотор чинь урьд нь гэмт хэрэг хийчихсэн хүн зүгээр иргэн болохоор хэзээ гэмт хэрэг хийсэн байх нь хамаагүй шүүхийн өмнө очдог байсан чинь Их хурлын гишүүн яг адилхан гэмт хэрэг хийчхээд очихгүй болонгуут наадах чинь шууд ялгаварлан гадуурхалт болоод эхэлчхэж байгаа байхгүй юу.

Их Хурлын гишүүний дархан эрх гэдэг чинь 1 дүгээр зорилго нь тэр гэмт хэрэгт хамруулах, хийсэн гэмт хэргээс нь хамгаалах биш 1 дүгээр зорилго нь гэмгүй Их Хурлын гишүүн айдасгүйгээр үгээ хэлдэг байх, тэрийг л хамгаалж байгаа тэргүүн зорилго ерөөсөө л энэ. Түрүүн Ганбаатар гишүүн яг энийг бас хэлж байх шиг байна. Их Хурлын гишүүний дархлаа гэдэг чинь айдасгүйгээр үгээ хэлэх боломжийг л олгох тухай асуудал. Тэгээд үүнтэй холбогдуулаад ярихад тэр өмнө нь Их Хурлын гишүүн гэдэг бол ямар ч гэмт хэрэгт холбогдоогүй гэдэг презунфицтэй субъект байхгүй юу. Яагаад гэвэл нэр дэвшихийн өмнө холбогдох байгууллагуудаас бид нар чинь гэмт хэрэгт холбогдож байгаагүй гэдэг бичиг авч байж сая нэр дэвших эрх чинь нээгдэж байгаа байхгүй юу. Тэр юуг хэлээд байгаа гэхээр энэ хуулиудын нийлбэр үйлчлэл юуг харуулаад байгаа гэхээр Их Хуралд орж ирж байгаа бол гэмт хэрэгт холбогдсон байж таарахгүй. Их Хурлын гишүүн бол гэмт хэрэгт холбогдоогүй хүн байх ёстой гэдэг ийм хуулийн нийлбэр үйлчлэлийн тайлбарыг нь аваад үзэх юм бол ингэж гарахаар байгаад байгаа юм.

Гэтэл сүүлдээ тайлбар нь явж байгаад өмнө нь хийсэн нь хамаагүй, яг гишүүн байхдаа хийсэнтэй нь л холбоотойгоор шалгана, өөрөөр шалгахгүй гэх юм бол энэ чинь бол ёстой Их Хурал засаглах аргагүй болно шүү дээ. Энэ Их Хурал ард иргэдийн итгэл үнэмшил дээр л тогтож байгаа байгууллага. Энэ төрийн болон нийгмийн хоорондын итгэлцэл алдрах юм бол засаглах тухай мартацгаах хэрэгтэй. Энэ чинь итгэлцэл дээр тогтож байгаа. Тэгэхээр тэр итгэлцлийг чинь зөв байдлаар л угаасаа бүрдүүлж байгаа учраас энэ дээр би юу хэлмээр байна гэхээр энэ асуудлын хэлэлцүүлгийг нарийн сайн судалж байж авч орж ирье. Шаардлагатай бол ажлын хэсгийг нь ч байгуулъя. Энийг бол заавал нарийн энэ Их Хурлын хүрээлэнгээр эрх зүйн бусад тинк танкууд юу вэ байна, тэд нараар нь санал онолыг нь бүгдийг нь авч байгаад, тал талаас нь авч үзэж байгаад оруулж ирье гэж бодож байна. Тийм учраас би үг хэлэх шат руугаа ч оролгүйгээр энийг хойшлуулж байна.

12.13 цаг.

3 дахь асуудал руугаа оръё.

Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/ асуудлыг хэлэлцэж эхэлье.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77.2-т заасан байгууллагуудад ажлын хэсэгт нэр авах тухай албан тоотыг хүргүүлж, холбогдох байгууллагуудаас ирүүлсэн нэрсийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1.6, 77.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон

Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 6.1, 6.2, 6.3 дахь хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь.

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн гишүүд С.Дондов Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Ж.Мөнхболд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга, Г.Оргилболд Улсын Их Хурал дахь Ардын намын бүлгийн ажлын албаны Хуулийн бодлогын хэлтсийн ахлах зөвлөх, Н.Ариунболд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх, Ч.Эрдэнэчимэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, М.Мөнхбат Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн, Л.Данзанноров Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч, Б.Дөлгөөн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Судалгааны төвийн дарга, Б.Амарсанаа Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Б.Нармандах Шихихутаг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, нэр дэвшигчийг Хууль зүйн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар томилогдсон Ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар гэсэн ийм ажлын хэсэг бүрэлдэхүүнтэйгээ байж байна. Ингээд одоо энэ уншиж танилцуулсан гишүүдийг нэр тус бүрээр нь санал хураалт явуулна.

Тэгэхээр ингэе. Асуулт, хариултаа нэгтгээд явчихъя. Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Ганбат гишүүн асуулт асууя гэж байгаа юм уу. Тэгвэл Ганбат гишүүнийг бас нэмээд оруулчих.

П.Сайнзориг: Дарга аа, зүгээр ийм зүйл байна. Энэ нөгөө ажлын хэсэгт бас төлөөллүүдийн ирж байгаа байдлыг харахаар Засгийн газар дээр шүүх, прокурортой харьцах асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд хариуцдаг юм. Гэтэл энэ чиг үүрэг нь байсаар байхад яагаад Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүнээ томилж явуулаад байгаа юм бэ. Ингэж болох юм уу. Энэ чинь Хууль зүйн сайд нь Энхбаяр сайд бол яг энийг сайд байхдаа анх эхлүүлж байсан санагдаад байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлаа өгч байсан байхгүй юу. Ангийнхаа хүүхэд. Тэгэхээр ингээд энэ чинь Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байх ёстой юмнуудыг одоо хэрэглэх газар буюу ийм байдлаар энэ чинь болохгүй ээ. Энийг нь буцаах хэрэгтэй, солиулах хэрэгтэй. Тэгвэл нэг мөсөн Хууль зүй, дотоод хэргийн яам энэ тэрээ буулгах ёстой байхгүй юу. Засгийн газрын төлөөлөл буюу Засгийн газрын чиг үүрэг дээр энэ чиг үүргийг чинь Засгийн газар дээр Хууль зүй, дотоод хэргийн сайд хариуцна гээд чиг үүргээ хуваачихсан шүү дээ сайд аа, Энхбаяр сайд аа. Тэгэхээр чинь Хууль зүй, дотоод хэргийн сайд нь мэдэхгүй ийм юмнуудыг ярьж болох юм уу. Энийг 1 дүгээрт солиулах хэрэгтэй.

2 дугаарт энэ хууль дээрээ Цогтоо дарга аа, хэзээ ч Шихихутаг их сургуулийн төлөөллийг оруулна гэж хууль батлаагүй байхгүй юу. Одоо энэ хар даа Бадарчийн

Нармандах Шихихутаг их сургуулийн төлөөлөл болж орно гэж байгаа байхгүй юу. Энэ хуулиар юу вэ гэхээр их, дээд сургуулийн төлөөлөл болж орно гэсэн болохоос биш энийг засуулах хэрэгтэй. Ийм юмнуудыг оруулж ирчхээд бид хэд ингээд цаашаа явах гэж байгаа бол буруу шүү. Энэ Шихихутуг их сургуулийн төлөөллийг байна гээд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар байгаагүй юм. Их сургуулийн төлөөлөл, ядаж энийгээ зөв бичиж орж ирэх ёстой. Их сургуулийн төлөөлөл болж байна. Шихихутуг их сургуулийг яагаад сонгосон юм. Энэ байдлыг тайлбарлах ёстой. Тэгээд Хууль зүй, дотоод хэргийн сайд нь мэдэхгүй байж байхад энд Шүүхийн тухай хуульд буюу тэр хүн шүүх, прокурортой Засгийн газрыг төлөөлж харьцах эрхтэй хүн нь юмаа өгөөгүй байж байхад энд ингээд Хэрэг эрхлэх газрын хуулийн хэлтсийн дарга ч байна уу, газрын дарга орж ирнэ гэдэг бол болохгүй шүү дээ. Энийг засаж оруулж байж энэ Байнгын хороо цаашдаа явахгүй бол болохгүй ээ. Болохгүй шүү нөхөд өө. Энд ер нь зарчим алдагдаад дуусаж байна. Тэгээд хэн чанга орилно, тэр хүн л ингээд давж ярьдаг. Тэгээд бусад дандаа хууль ярихаар чи хэн юм. Хэмжээндээ бай, дуугүй бай ийм л зүйл ингээд бүх түвшинд явж дууслаа.

Тэгэхээр энийг Байнгын хорооны дарга аа, засуулж байж энэ хүмүүсийн нэрийг солиулж байж явах ёстой шүү.

Д.Цогтбаатар: Үгүй ээ, үгүй. Энэ дээр ийм шүү дарга аа. Алдаа бол биш. Тийм учраас хүн болгон дээр санал хураана шүү дээ. Тэгээд биш бол энийгээ солиод л явна шүү дээ. Энэ Шүүхийн тухай хууль дээр 77.2 дээр хаана хаанаас авах вэ гээд заачихсан байгаа. Тэр дотроо Засгийн газар гээд заачихсан. Бид нар Засгийн газар луугаа явуулж байгаа. Засгийн газраас ирж байгаа хариу л энэ байгаа байхгүй юу. Тэгэхгүй бид нар Засгийн газар гээд заачихсан байхад Засгийн газрын Хэрэг эрхлэх газар луугаа л явуулахгүй бол би сонгоод Хууль зүйн яам гэж явуулахгүй шүү дээ. Засаг өөрөө тэр дотроо хаанаас, хэнээсээ ирүүлэх вэ гэдгээ л шийднэ.

Тэр сургуулийн тухайд гэвэл ахиад л энд нөгөө хувийн сургууль байх ёстой. Түрүүний удаа Отгонтэнгэр гэж сургууль орж байсан юм. Одоо ингээд Шихихутуг. Тэгээд та нар санал хураагаад энэ дээр биш ээ гэвэл биш л байхгүй юу. Отгонтэнгэр гээд сургууль ноднин ороод л явж байсан байхгүй юу. Тэрийгээ манай редакцынхан бодно биз. Тэгэхээр Сайнзориг гишүүн ээ, яг хүн хүнээрээ санал хураагаад л энэ дээрээ байр сууриа гишүүд илэрхийлээд л явчихна. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Энэ нөгөө гишүүн болгоноор нь саналаа хураагаад явах байх. Урьд нь бол 3 удаа Хуульчдын холбооны төлөөлөл унаж байсан шүү дээ. Би тэгж санаж байна. Тэр нь яасан гэсэн чинь нөгөө зөвлөлөөрөө хэлэлцээгүй Хуульчдын холбоо ирүүлээд байсан байхгүй юу. Тэгээд Байнгын хороо дээр унаад, энэ ковидын үе байсан юм. Ийм асуудал болж байсан санагдаж байна. Яах вэ, энэ Ардчилсан намын бүлэг сая Сайнзориг гишүүн микрофонгүй хэлчихсэн. Энийг яриад яах вэ тэгвэл.

Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсгийг сонгох юм байна. Тэгээд манай Байнгын хорооны гишүүдээс сонгогдож таарна байх. Тийм учраас энэ дээр бол тийм сонирхлын зөрчилгүй хүнийг томилбол их зүгээр байна. Ний нуугүй хэлэхэд Амарбат гэж Их Хурлын даргын өмгөөлөгч хуульчидтай уулзалт хийгээд, Их Хурлын даргатай уулзуулъя. Чи дэвшчих, би дэвшчих гэсэн уулзалтууд хийсэн. Энэ хүн өөр бусад бас уулзалтууд хийсэн байгаа. Тийм учраас энэ сонирхлын зөрчлийн асуудлыг нэлээн сайн ярьж байж сонирхлын зөрчилгүй хүн ажлын хэсэг ахлуулмаар байна. Сонирхлын зөрчилгүй хүн. Би бол Ганбат гишүүнийг байвал яасан юм бэ гэж

бодоод байх юм. 3 удаа сонгогдсон, Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байсан, 2 удаа Нүүрсний сонсгол, Хөгжлийн банкны сонсголд бас оролцож байсан. Энэ хүнтэй холбоотой ямар нэгэн нүүрс, хөгжлийн банк гэсэн юм бол илэрч байгаагүй. Хэдийгээр бор царайтай ч гэсэн жинхэнээсээ харин доторх нь бол цагаан сүү шиг хиргүй тунгалаг хүн байна гэж би бол ойлгож явдаг. Тийм учраас Ганбат гишүүнийг Байнгын хорооноосоо санал болгоод явуулбал яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүн үгээ хэлье.

Д.Ганбат: Энэ ч бас нэлээн чухал ажлын нэг л дээ. Тэгээд энэ ажлын хэсгийн гишүүд гэж л байна л даа. Энэ ажлын хэсгийн гишүүдийгээ нөгөө хуулийнхаа зүйл заалтаар оруулж ирж байгаа. Гэхдээ сонирхлын зөрчилгүй, ашиг сонирхлын зөрчилгүй тийм хүмүүс орж ирсэн байх ёстой. Нөгөө тэр явуулж байгаа байгууллага нь хурал хуугаа хийгээд, хоорондоо яриад, тэр протоколтойгоо явуулсан байх ёстой. Тэр юмнууд нь байгаа юу. Тэгж явж байгаа юу гэсэн зүйлийг би Байнгын хорооны даргаасаа асуумаар байна.

Энхбаяр гишүүнийг бас ингээд хамт ажиллаад, хууль тогтоогоод олон жил болсон. Тэгээд намайг бас тодорхойлж байгаад баярлалаа. Тэр ярьж байгаа, хэлж байгаа, тэр хүлээлтэд нь хүртэл ажиллахыг хичээнэ. Ер нь бол манай Хууль зүйн байнгын хороо сайн ажиллаад ирэхээрээ намайг ахалж байхад 2015 онд бид нар авлигатай тэмцэх энэ юмаараа бол 77-д байсан шүү дээ. Би бас зүгээр тоо баримт ярих хэлэх хэрэгтэй байх гэж бодож байна. Шүүхийн хараат бус байдал бол тэр үед маш их сайжирч байсан. Хамгийн сайн үзүүлэлт тэр үед байсан юм. Тэгээд энэ ажлыг бол хийхэд бэлэн байна. Баярлалаа. Өөр зүйл алга.

Д.Цогтбаатар: Тэгэхээр Ганбат гишүүн ээ, энэ бол нөгөө хуулийн хугацаатай процесс байдаг. Бид нар албан тоотоор нөгөө байгууллагууд руу ийм хүнээ дэвшүүлээд явуулаач ээ гээд, нөгөө байгууллагууд өөрсдөө өөрийнхөө журмаар нэрсээ дэвшүүлээд л явуулж байгаа юм. Одоо бид нар өөрийнхөө түвшинд бол шалгаад, үзээд л явж байгаа юм. Жишээлбэл саяын гишүүдийн ярьж байгаа асуудлуудыг бид нар мэдэж байгаа. Ардчилсан намаас нэр дэвшүүлээд явуулж байгаа хүнд бид нар хажуугаас ороод үгүй ээ ийм байна гэхгүй. Одоо энд ингээд санал хураагаад, сая яг асуудлуудыг ярьж байна шүү дээ. Энэ дээр ийм бас асуудал байна шүү. Ашиг сонирхлын зөрчил байж болзошгүй эрсдэл байна шүү гээд. Тэгэхээр энийг бол санал хураагаад л явуулахгүй бол би өөр намын юунд наад хүнээ та соль гэдэг ийм асуудал байж болохгүй. Ардчилсан нам, манай нам, аль аль ч намууд бүгдээрээ энэ Байнгын хороонд төлөөлөлтэй байгаа. Тэгээд шийдвэрээ гаргаад, хувь хүн болгон дээр нь бид нар шийдвэрээ гаргаад л явна.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан учраас нэг бүрчлэн саяын энэ ажлын хэсгийн гишүүдээр санал хураалт явуулна.

1.Монголын Өмгөөлөгчдийн холбооноос санал болгосон Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч Лхагваагийн Данзанноровыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад гишүүд бэлдээрэй. Саяын томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 87,5 хувиар санал дэмжигдлээ.

2 дугаар нэр дэвшигч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас санал болгосон Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Жаргалсайханы Мөнхболдыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 87,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс санал болгосон Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны Хуулийн бодлогын хэлтсийн ахлах зөвлөх Ганбатын Оргилболдыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 81,3 хувиар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос санал болгосон Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Сангишаравын Дондовыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал орж ирж байгаа нь энэ дарааллаар биш байхгүй юу. 4 дэх хүнийг би сая уншиж танилцуулсан. Хүний эрхийн Үндэсний Комиссын Дондов гуай байгаа. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 87,5 хувиар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс санал болгосон Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Намсрайн Ариунболдыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 25 хувиар санал дэмжигдсэнгүй.

2 хоногийн дотор тэгэхээр Ардчилсан намын бүлгээс энэ саналаа шинэчилж ирүүлэх хэрэгтэй болно. Санал хураалт дэмжигдсэнгүй.

6.Монголын Хуульчдын холбооноос санал болгосон Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн Мөнхдоржийн Мөнхбатыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 68,8 хувиар санал дэмжигдлээ.

Эрдэнэболд гишүүнийг дэмжсэнээр тэмдэглэе. Саяын Мөнхбат нэр дэвшигчийн санал хураалт дээр.

7.Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академиас санал болгосон Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Баттулгын Дөлгөөнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 75 хувиар санал дэмжигдлээ.

8.Монгол Улсын Засгийн газраас санал болгосон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Чойжилжавын Эрдэнэчимэгийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 43 хувиар санал дэмжигдсэнгүй.

2 хоногийн дотор тэгэхээр саналыг эргүүлж Засгийн газраас бид нарт өгөх ёстой.

9.Төрийн бус өмчийн хууль зүйн сургуулиас санал болгосон Шихихутаг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн захирал Бадарчийн Нармандахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 81 хувиар санал дэмжигдлээ.

Энэ дээр тэр редакцын засварыг Байнгын хорооны ажлын алба хийгээрэй.

10.Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулиас санал болгосон Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Батболдын Амарсанааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 87 хувиар санал дэмжигдлээ.

11.“Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа дарга аа, би тэр нөгөө Шихихутаг сургуулийн төлөөлөл биш гэдэг утгаар нь редакция хийгээрэй. Зүгээр хууль зүйн сургуулиудын төлөөлөл шүү гэдэг утгаар хэлж байгаа шүү тэр хүн дээр. Тэрийг нь бас протоколд зөв оруулж өгөөрэй.

2 дугаарт энэ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77.2-ыг уншихмаар байна. Ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Хүний эрхийн Комисс, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн сургууль, Судалгааны байгууллага, Хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдэнэ гэсэн. Гэтэл бид нар Улсын дээд шүүхийн дэргэд ажиллаж байгаа Судалгааны хүрээлэн буюу шүүгч нарын төлөөллийг шууд энд оруулчихлаа. Болохгүй. Тэгэхээр энэ Дөлгөөн гэдэг хүний хураасан саналыг цуцлаад, судалгааны өөр төвүүд байж болно. Хууль зүйн үндэсний хүрээлэн өөр юу байдаг юм. Энэ ингэхгүй бол байна шүү дээ. Улсын дээд шүүхийн дэргэд ажиллаж байгаа Судалгааны хүрээлэн чинь шүүгч бус гишүүнийг яаж болохгүй шүү дээ. Сонгон шалгаруулалтад оролцож болохгүй. Тэгэхээр бид хэд энэ юмнуудаа зөв зохион байгуулахгүй бол ингээд Хууль зүйн байнгын хорооны гишүүдээр хууль зөрчсөн ийм хураалгаад байх юм. Энийгээ цуцалмаар байна. Би сая горимын санал гаргаад Дөлгөөн гэдэг хүн дээр хураасан, би тэр Дөлгөөн гэдэг залуу дээр ч юм уу, эмэгтэй хүн ч юм уу мэдэхгүй байна. Ашиг сонирхлын зөрчил байхгүй. Хувь хүний сэдэл байхгүй. Зүгээр энэ бол болохгүй зарчим шүү л гэдэг агуулгаар нь би хэлж байгаа юм. Тэгэхээр энийг гишүүд маань бас анхааралдаа аваад, би горимын санал гаргаж болж байна. Өөр судалгааны хүрээлэн байдаг юм уу, судалгааны институтээс оруулж ирэх ёстой. Үгүй ээ, тэгэхээр яг Улсын дээд шүүхийн дэргэд ажиллаж байгаагаас болохгүй байхгүй юу даа. Шүүгч бус гишүүнийг. Шүүгч нар чинь 5-ыг илгээчихсэн шүү дээ. Сая нийт шүүгчдийн хуралдаанаар. Тэгэхээр би зүгээр зарчмын хувьд л юм хэлж байгаа шүү. Тэгэхээр хууль зүйн сургуулиудын дэргэд судалгааны төвүүд бий. Хууль зүйн үндэсний хүрээлэн гээд Засгийн газрын дэргэд байна. Өөр юу байдаг юм. Энийгээ судалж байгаад яахгүй бол.

Д.Цогтбаатар: Үгүй ээ, үгүй. Энэ чинь шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах тухай яриад байна шүү дээ. Тийм учраас шүүхийн дэргэд байхад чинь ямар ч энэ дээр ашиг сонирхлын зөрчил байхгүй шүү дээ. Тэгэхгүй бол одоо бид нар харин энэ шүүхтэй холбоотой асуудлаар илүү мэргэжлийн хүн оруулж ирэхэд тэндээс нь хүн тэгээд энэ чинь судалгааны хүрээлэн байхгүй юу. Бас яг шүүхийнх нь байгууллага биш. Тэр хүрээлэн нь юм чинь. Санал хураагаад явчихсан юм чинь энэ юугаараа явчихъя. Горимын саналаа гарга, гарга.

П.Сайнзориг: Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 5 гишүүнийг сонгохдоо Улсын дээд шүүхийн судалгааны хүрээлэнгээс хүн оролцох нь бол зохимжгүй ээ 1 дүгээрт.

2 дугаарт Хууль зүйн байнгын хорооноос баталсан журам нь байгаа. Энэ журам дээрээ Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн төлөөлөл байна гэдэг зүйлийг батлаад, мөрдүүлээд явж байгаа. Үүндээ нийцүүлээд зөрчилдөж байгаа энэ санал буюу тэр нэр дэвшигч Дөлгөөний саналыг хүчингүй болгож өгөх горимын саналыг гаргаж байна.

Д.Цогтбаатар: Тэгэхээр Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академиас санал болгосон Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Баттулгын Дөлгөөнийг түрүүн дэмжье гэсэн томьёоллоор санал хураасан. Одоо энийг хүчингүй болгоё гэсэн ийм горимын санал гаргаж байна. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Энэ гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Үгүй ээ тэгээд. Санал хураалаа шүү дээ. Би бол дэмжлээ. Өөрөө харж байгаа биз. Үгүй ээ, үгүй наадах чинь ийм шүү Уянгахишиг гишүүн ээ. Бид нар хуулиа л барина. Бас журам дээр чинь байна шүү дээ. Адилхан хууль зүйн сургалт судалгааны төв гэж яг хууль дээр бол ерөнхий судалгааны төвүүд гээд заачихсан байж байгаа байхгүй юу. Харин тэгээд ганцхан юу заачихсан байгаа байхгүй юу. Үгүй ээ, би тэрийг чинь яах юм бэ. Тэгэхдээ Сайнзоригоо би горимын саналаар сая санал хураалгалаа. Тэгээд гишүүд саналаа өглөө. Би өөрийн чинь горимын саналыг дэмжлээ. Тэгээд энэ дэмжигдээгүй энэ гарч байгаа шийдвэрийг би яах юм бэ.

Одоо тэгээд цаашаа үргэлжлүүлээд явъя.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг ... манайхан тайван сонсож бай л даа. “Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Би дэг зохиож чадахгүй шүү дээ. 64,7 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

12.53 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ